

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019-02-27

Тендер шалгаруулалтын нэр: Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/

Тендер шалгаруулалтын код: ЗГХЭГ/201902023

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын барилгын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000,0 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж нь санал болгож буй үний 40 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн 30 хувиас багагүй

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил 2017, 2018

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Төсөвт өртөгийн 40 хувиас багагүй

Барилга угсралтын тусгай зөвшөөрөл шаардлагатай

Тендерийн хамт 12,000,000 төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2019 оны 03-р сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 03-р сарын 29-ний өдрийн, 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс авч болно.

Дундговь аймгийн  
Орон нутгийн өмчийн газар 70593399, 88900015